



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 7/103

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.10 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны “Нийтлэг шаардлага батлах тухай” А/174 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын “Хүснэгт 1. Ерөнхий суурь хичээлийн чиглэлүүд”-д дор дурдсан нэмэлт оруулсугай.

9. Гамшгаас хамгаалах менежментийн үндэс	Эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан шатны тусlamж үзүүлэх чадвар эзэмшиүүлэх	1 багц цаг хүртэл
--	--	-------------------

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны “Нийтлэг шаардлага батлах тухай” А/174 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын “Хүснэгт 1. Ерөнхий суурь хичээлийн чиглэлүүд”-ийн 8 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчилсүгэй.

8. Биеийн тамир, эрүүл ахуй	Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл, чийрэг амьдрах ухаанд суралцах, бие даан спортоор хичээллэх,	3 багц цаг хүртэл
-----------------------------	--	-------------------

3. Биеийн тамир, эрүүл ахуй, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс хөтөлбөрийг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн нийт суралцагчдыг хамруулан чанартай, үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг дээд боловсролын сургалтын байгууллагын захирал нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын бодлогын газарт үүрэг болгосугай.

САЙД

Г.ЧУЛУУНБААТАР

13 1193